



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ
“МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ 2024 ОН
ХҮРТЭЛ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ”
12 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

Улаанбаатар хот
2023 он

АГУУЛГА

УДИРТГАЛ

НЭГ.МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ 2024 ОН ХҮРТЭЛ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ҮНДСЭН ЧИГЛЭЛД ТУСГАГДСАН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ТАЛААР

1.1.Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийн талаар

1.2.Улсын Их Хуралд өргөн мэдүүлээгүй хууль тогтоомжийн төслийн талаар

ХОЁР.МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ 2024 ОН ХҮРТЭЛ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ҮНДСЭН ЧИГЛЭЛД ТУСГАГДААГҮЙ БОЛОВЧ УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ТАЛААР

ДҮГНЭЛТ

Хүснэгтийн товъёг

Хүснэгт 1.Өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийн мэдээлэл
Хүснэгт 2.Өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийн мэдээлэл /оноор/
Хүснэгт 3.Өргөн мэдүүлээгүй хууль тогтоомжийн төслийн мэдээлэл /оноор/

Зургийн товъёг

Зураг 1.Үндсэн чиглэлд тусгагдсан хууль тогтоомжийн төслийн төрөл
Зураг 2.Хууль тогтоомжийн төсөл өргөн мэдүүлсэн байдал

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ
“МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ 2024 ОН ХҮРТЭЛ
БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ”
12 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

Удиртгал

Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын ажлын цаглаварт туссан Монгол Улсын Их Хурлын 2021 оны “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” 12 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцад 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар хяналт шинжилгээ хийлээ.

Хууль тогтоомжийн тухай хуульд Засгийн газар тухайн бүрэн эрхийнхээ хугацаанд санаачлах хууль тогтоомжийн талаар урьдчилан төлөвлөж, Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгах, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох байгууллагын саналыг авч, нэгтгэн судалсны үндсэн дээр Үндсэн чиглэлийн төслийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн боловсруулахаар заасан.

Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдөр “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг өргөн мэдүүлж, 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 12 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байна.

Хяналт шинжилгээний зорилго:

Хууль тогтоомжийн тухай хуулийн 50 дугаар зүйлд “... хууль тогтоомжийн зорилгыг хангаж байгаа түвшинг тодорхойлох, хууль тогтоомжийн үзэл баримтлалд тодорхойлсон үр дүнд хүрэх байдлыг тогтоох чиглэлээр хяналт шинжилгээ хийнэ” гэж заасны дагуу “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоол батлагдсанаар Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх үйл ажиллагаа 4 жилийн хугацаагаар төлөвлөгдөнө гэсэн тогтоолын үзэл баримтлалаар дэвшүүлсэн үр дагавар бий болсон эсэх, зорилго хангагдаж чадсан эсэхийг тогтоох зорилгоор хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийлээ.

Судалгааны аргачлал, арга зүй:

“Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” 12 дугаар тогтоолын хэрэгжилтэд явцын хяналт шинжилгээ хийхдээ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан “хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх аргачлал”-ыг удирдлага болгон хяналт шинжилгээ хийлээ. Мөн тус тогтоол нь өөрийн зорилго, үзэл баримтлалаар тодорхойлсон үр дүнд хүрсэн эсэх, хэрэгжилтийн явцын өнөөгийн байдлыг тогтоох үүднээс баримт бичгийн болон статистик дүн шинжилгээний арга зүйг ашигласан.

Улсын Их Хурлын ээлжит чуулганаар баталсан хууль, Улсын Их Хурлын тогтоолын жагсаалт, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болон хэлэлцүүлгийн шатанд

байгаа хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийн жагсаалт болон уг жагсаалттай нийцүүлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл, түүнчлэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн ХЭГ/3189 дүгээр албан бичгээр ирүүлсэн мэдээлэл зэрэгт тулгуурлан тус тогтоолын хэрэгжилтийн явцыг гаргасан болно.

НЭГ.МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ 2024 ОН ХҮРТЭЛ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ҮНДСЭН ЧИГЛЭЛД ТУСГАГДСАН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ТАЛААР

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д 2021-2023 онд Засгийн газраас 167 хууль тогтоомжийн төслийг санаачилж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасан.

“Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д 2021-2023 онд Засгийн газраас 167 хууль тогтоомжийн төслийг санаачилж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасан бөгөөд хууль тогтоомжийн төслийг төрлөөр нь авч үзвэл:

- Анхдагч хуулийн төсөл - 45;
- Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл - 56;
- Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл - 43;
- Олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төсөл - 9;
- Улсын Их Хурлын тогтоолын төсөл – 14 байна.

Зураг 1.



Зураг 2.



“Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Засгийн газраас санаачилж өргөн мэдүүлэхээр тусгасан 167 хууль тогтоомжийн төслөөс 67 хууль тогтоомжийн төсөл буюу 40.1 хувийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, 100 хууль тогтоомжийн төсөл буюу 59.9 хувийг өргөн мэдүүлээгүй байна.

1.1.Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийн талаар:

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн 67 хууль тогтоомжийн төслөөс анхдагч хуулийн төсөл 15, шинэчилсэн найруулгын төсөл 28, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 12, олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төсөл 4, Улсын Их Хурлын тогтоолын төсөл 8 байна. Үүнд:

- Өргөн мэдүүлсэн 15 анхдагч хуулийн төслөөс батлагдсан 6 хууль, хэлэлцүүлгийн шатанд 7 хуулийн төсөл, хэлэлцэж эхлээгүй 2 анхдагч хуулийн төсөл;
- Өргөн мэдүүлсэн 28 хуулийн шинэчилсэн найруулгын төслөөс батлагдсан 9 хууль, хэлэлцүүлгийн шатанд 18 хуулийн төсөл, хэлэлцэж эхлээгүй 1 хуулийн төсөл;
- Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 12 хуулийн төслөөс батлагдсан 7 хууль, хэлэлцэх шатанд 4 хуулийн төсөл, хэлэлцэж эхлээгүй 1 хуулийн төсөл;
- Өргөн мэдүүлсэн олон улсын гэрээ соёрхон батлах тухай 4 хуулийн төслөөс батлагдсан 2 хууль, хэлэлцэж эхлээгүй 2 хуулийн төсөл;
- Өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын 8 тогтоолын төслөөс батлагдсан 2 тогтоол, хэлэлцэж эхлээгүй 6 тогтоолын төсөл тус тус байна.

Хүснэгт 1.Өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийн мэдээлэл:

	Хууль тогтоомжийн төслийн төрөл	Өргөн мэдүүлсэн	Үүнээс:		
			Батлагдсан	Хэлэлцүүлгийн шатанд	Хэлэлцэж эхлээгүй
1	Анхдагч хуулийн төсөл	15	6	7	2
2	Шинэчилсэн найруулгын төсөл	28	9	18	1
3	Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	12	7	4	1
4	Олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төсөл	4	2	-	2
5	Улсын Их Хурлын тогтоолын төсөл	8	2	-	6
	Нийт	67	26	29	12

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн 67 хууль тогтоомжийн төслөөс батлагдсан 26, хэлэлцэх шатанд 29, хэлэлцэж эхлээгүй 12 хууль тогтоомжийн төсөл байна.

Өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцыг оноор авч үзвэл:

- 2021 онд нийт 122 хууль тогтоомжийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээс 59 хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлж, 63 төслийг өргөн мэдүүлээгүй байна. Өргөн мэдүүлсэн 59 хууль тогтоомжийн төслөөс батлагдсан 24, хэлэлцэх шатанд 28, хэлэлцэж эхлээгүй 7 хууль тогтоомжийн төсөл байна.
 - √ Батлагдсан 24 хууль тогтоомжоос анхдагч хууль 6, хуулийн шинэчилсэн найруулга 8, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 7, олон улсын гэрээ соёрхон батлах тухай хууль 2, Улсын Их Хурлын тогтоол 1;
 - √ Хэлэлцэх шатанд байгаа 28 хууль тогтоомжийн төслөөс анхдагч хуулийн төсөл 6, хуулийн шинэчилсэн найруулгын төсөл 18, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 4;
 - √ Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн боловч хэлэлцэж эхлээгүй 7 хууль тогтоомжийн төслөөс анхдагч хуулийн төсөл 2, хуулийн шинэчилсэн

найруулгын төсөл 1, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 1, олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төсөл 2, Улсын Их Хурлын тогтоолын төсөл 1 тус тус байна.

- 2022 онд нийт 33 хууль тогтоомжийн төсөл өргөн мэдүүлэхээс 7 хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлж, 26 төслийг өргөн мэдүүлээгүй байна. Өргөн мэдүүлсэн 7 хууль тогтоомжийн төслөөс батлагдсан 2, хэлэлцэж эхлээгүй 5 төсөл байна.
 - √ Хуулийн шинэчилсэн найруулга 1 батлагдсан;
 - √ Улсын Их Хурлын 1 тогтоол батлагдсан;
 - √ Улсын Их Хурлын 5 тогтоолын төслийг өргөн мэдүүлсэн бөгөөд хэлэлцэж эхлээгүй байна.
- 2023 онд нийт 12 хууль тогтоомжийн төсөл өргөн мэдүүлэхээс 1 хуулийн төслийг өргөн мэдүүлж, 11 хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлээгүй байна.
 - √ 1 анхдагч хуулийн төсөл хэлэлцэх шатанд байна.

Хүснэгт 2. Өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийн мэдээлэл /оноор/:

Хууль тогтоомжийн төслийн төрөл	Өргөн мэдүүлсэн	2021 он			2022 он			2023 он		
		Батлагдсан	Хэлэлцүүлгийн шатанд	Хэлэлцэж эхлээгүй	Батлагдсан	Хэлэлцүүлгийн шатанд	Хэлэлцэж эхлээгүй	Батлагдсан	Хэлэлцүүлгийн шатанд	Хэлэлцэж эхлээгүй
Анхдагч хуулийн төсөл	15	6	6	2	-	-	-	-	1	-
Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	28	8	18	1	1	-	-	-	-	-
Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	12	7	4	1	-	-	-	-	-	-
Олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төсөл	4	2	-	2	-	-	-	-	-	-
Улсын Их Хурлын тогтоолын төсөл	8	1	-	1	1	-	5	-	-	-
	67	24	28	7	2	-	5	-	1	-

1.2. Улсын Их Хуралд өргөн мэдүүлээгүй хууль тогтоомжийн төслийн талаар:

“Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д 2021-2023 онд Засгийн газраас 167 хууль тогтоомжийн төслийг санаачилж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр зааснаас 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 100 хууль тогтоомжийн төсөл буюу 59.9 хувийг өргөн мэдүүлээгүй байна.

Хүснэгт 3. Өргөн мэдүүлээгүй хууль тогтоомжийн төслийн мэдээлэл /оноор/:

	Хууль тогтоомжийн төслийн төрөл	Өргөн мэдүүлээгүй	Он		
			2021	2022	2023
1	Анхдагч хуулийн төсөл	30	18	8	4
2	Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	28	19	7	2
3	Хуульд нэмэлт, өөрчлөлт	31	23	6	2

	оруулах тухай хуулийн төсөл				
4	Олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төсөл	5	-	3	2
5	Улсын Их Хурлын тогтоолын төсөл	6	3	2	1
	Нийт	100	63	26	11

Улсын Их Хуралд өргөн мэдүүлээгүй 100 хууль тогтоомжийн төслөөс анхдагч хуулийн төсөл 30, хуулийн шинэчилсэн найруулгын төсөл 28, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 31, олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төсөл 5, Улсын Их Хурлын тогтоолын төсөл 6 тус тус байна.

Тогтоолын хавсралтаар батлагдсан хууль тогтоомжийн төслийн хэрэгжилтийн явцын дэлгэрэнгүй мэдээг хавсралтаас үзнэ үү.

ХОЁР.МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ 2024 ОН ХҮРТЭЛ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ҮНДСЭН ЧИГЛЭЛД ТУСГАГДААГҮЙ БОЛОВЧ УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ТАЛААР

Монгол Улсын Их Хурлын 2021 оны “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” 12 дугаар тогтоолын 3-т “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгагдаагүй боловч нэн шаардлагатай гэж үзсэн хууль тогтоомжийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлж байхыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т үүрэг болгосугай” гэж заасан.

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн ХЭГ/3189 дүгээр албан бичгээр “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хэрэгжилтийн мэдээлэл ирүүлсэн. Дээрх мэдээлэлд нэн шаардлагатай гэж үзсэн 11 хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлснээс 7 хууль, УИХ-ын 2 тогтоол батлагдаж, 2 хуулийн төсөл хэлэлцэх шатанд байна. Үүнд:

Батлагдсан хууль тогтоомж:

- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль;
- Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хууль;
- “Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд байгуулсан Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хууль;
- “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын 2021 оны 56 дугаар тогтоол;
- “Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын 2022 оны 23 дугаар тогтоолыг тус тус батлуулсан байна.

Хэлэлцэх шатанд байгаа хууль тогтоомжийн төсөл:

- Байгалийн ургамлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;
- Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл тус тус хэлэлцүүлгийн шатанд байна.

Дүгнэлт

1. Тус тогтоолын хэрэгжилт хангалтгүй буюу “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д тусгагдсан нийт 167 хууль тогтоомжийн төслөөс 67 хууль тогтоомжийн төсөл буюу 40.1 хувийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, **100 хууль тогтоомжийн төсөл буюу 59.9 хувийг өргөн мэдүүлээгүй байна.**
2. Мөн тус тогтоолын 3-т “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн биелэлтийг зохион байгуулж, хэрэгжилтийн тайланг жил бүрийн намрын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд танилцуулахыг Засгийн газарт үүрэг болгосон боловч хэрэгжилт хангалтгүй буюу тогтоолын хэрэгжилтийг Улсын Их Хуралд танилцуулаагүй байна.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийхэд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн шаардлагатай мэдээлэл дутуу, нэгдсэн дүн шинжилгээ хийгдээгүй, батлагдсан жагсаалтын дагуу эрэмбэлэгдээгүй зэрэг боловсруулалтын шатны алдаатай ирж байгаа нь хяналт шинжилгээ хийх ажилд хүндрэл учруулж байна.

Хавсралт 8 хуудас.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР